

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН  
2017 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,  
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТУХАЙ

2018 оны 01 дүгээр  
сарын 31-ний өдөр

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээний хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээг хийв.

Улсын Их Хурлын 2016 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 51 дүгээр тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”, Засгийн газрын 2017 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 114 дүгээр тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний хүрээнд 6 зорилтыг хэрэгжүүлэхээр тусгасан.

***2017 оны жилийн эцсийн байдлаар “үр дүнтэй”-зорилт, арга хэмжээ нь оновчтой тодорхойлогдсон, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан 100 хувийн хэрэгжилттэй 6 арга хэмжээ байна. Үүнд:***

**Зорилт 1.** шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх;

4.1.1.1.1. Онцгой байдлын ерөнхий газрын [www.nema.gov.mn](http://www.nema.gov.mn) цахим хуудасны “Салбар зөвлөлийн булан”-д сул ажлын байрны зар болон төрийн албаны зөвлөлийн талаарх мэдээлийг байршуулан холбогдох мэдээллийг нийтэд хүргэн ажиллаж байна.

Онцгой байдлын ерөнхий газрын цахим хуудсыг Төрийн албаны зөвлөлийн цахим хуудастай холбон шаардлагатай мэдээ, мэдээллийг тус хуудсаар дамжуулан төв, орон нутаг онцгой байдлын газар, анги, байгууллагуудад хүргүүлж байна. Төв орон нутаг онцгой байдлын газар, анги, байгууллагуудын цахим хуудсаар тухайн орон нутагт гарч болзошгүй гамшгийн ослоос урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, мэдээг тогтмол байршуулан нийтэд мэдээлэх ажил хэвшээд байна.

Онцгой байдлын ерөнхий газрын [nema.gov.mn](http://nema.gov.mn) цахим хуудсны “Төрийн албаны салбар зөвлөл” буланд 2017 оны жилийн эцсийн байдлаар нээлттэй ажлын байрны зарыг 2 удаа, Төрийн тусгай албанд анх орох иргэний ажлын байрны зарыг 2 удаа тус тус байрлуулсан.

4.1.1.1.2. Онцгой байдлын байгууллагад шинээр ажиллах, дэвшин ажиллах 2017 онд нийт 143 иргэн, алба хаагчдын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулахаар цаасаар хүлээн авч, Авлигатай тэмцэх газарт хүргүүлэн хянуулсан болно.

4.1.1.2.1. Монгол Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам"-ын 10, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолын 2.4.1-д заасны дагуу салбар зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн Онцгой байдлын ерөнхий газрын Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга, Гал түймрийн улсын хяналтын хэлтсийн дарга, нийслэлийн Онцгой байдлын газрын дарга, орлогч, Уул уурхайн аврах ангийн захирагч гэх мэт нийт ... албан тушаалд нэр дэвшүүлэх ... албан тушаалтны асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, холбогдох мэдээллийг Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн.

4.1.1.7. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс төв, орон нутгийн онцгой байдлын газар, анги салбаруудын үйл ажиллагаанд төлөвлөгөөт шалгалт хийж, онцгой байдлын байгууллагын 2700 гаруй алба хаагчдад нэгдсэн мэдээлэл, танилцуулга зохион байгуулсан.

Энэ хүрээнд ёс зүйн зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн гаргах, авах нөхцөлийг бүрдүүлж, 7 асуулга бүхий нэргүй судалгаа авч, дүн шинжилгээ хийснээр албаны үйл ажиллагаанд анхаарах асуудлын судалгааг гаргаж, сахилга, ёс зүйн зөрчлийг арилгах нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлээд байна.

Онцгой байдлын байгууллагын хэмжээнд 2017 онд 3397 бичгээр, 59 амаар, нийт 3456 гаргасан өргөдөл, гомдол бүртгэгдснээс хугацаанд хариу өгч шийдвэрлэсэн 3266, хуулийн хугацаанд судлагдаж байгаа 51, хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн 139 өргөдөл, гомдол байгаа бөгөөд албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбогдсон өргөдөл, гомдол иргэд, алба хаагчдаас ирүүлээгүй болно.

Тайлант хугацаанд буюу 2017 оны байдлаар ашиг сонирхлын зөрчил үүссэн буюу үүсч болзошгүй тохиолдол бүртгэгдээгүй бөгөөд Монгол Улсын Засгийн газрын хөрөнгө оруулалт, төсвийн хөрөнгөөр зарласан тендер, үнэлгээний хороонд ажилласан нийт 210 мэдэгдэл тайлбарыг авч, ХАСХОМ бүрдүүлэлтийн цахим системд бүртгэсэн.

4.1.1.10.1. Онцгой байдлын ерөнхий газраас 2017 онд орон нутгийн Онцгой байдлын газрын дарга, хүний нөөц, нягтлан бодогч, нөөцийн салбарын дарга, гамшгийн болон гал түймрийн улсын хяналтын байцаагч зэрэг нийт 1751 албан тушаалтанд 41 сургалт, цугларалт зохион байгуулсан нь 2016 оноос 247 алба хаагч буюу 16 хувиар өссөн байна. Авлигатай тэмцэх газрын холбогдох мэргэжилтнээс сургалт авч, сургалтын бааз байгуулан ажиллав. Онцгой байдлын ерөнхий газраас

2018 онд зохион байгуулах сургалтын төлөвлөгөөг гарган батлуулж, хуваарийн дагуу хэрэгжүүлж эхлээд байна.

4.1.1.10.2. Онцгой байдлын байгууллагын хэмжээнд 2017 онд зохион байгуулагдах дотоод сургалтын төлөвлөгөө гарган АТГ-ын холбогдох мэргэжилтнүүдийг урьж оролцуулан “Авлигын эсрэг хууль, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх” чиглэлийн сургалт зохион байгуулж албан тушаалтны сургалт, цугларалт бүрт Захиргааны удирдлагын газраас алба хаагчдад давтан сургалтыг зохион байгуулж ажиллав. Мөн 2018 оны хичээлийн жилийн нээлт хийж алба хаагчдад 2018 онд албаны хэмжээнд 5 чиглэлээр 40 сургалтыг зохион байгуулах сургалтын төлөвлөгөөг танилцуулав.

4.1.1.10.3. Онцгой байдлын байгууллага АТГ-с холбогдох мэргэжилтнүүдийг оролцуулан “Авлигын эсрэг хууль, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх” чиглэлийн сургалтыг заалгахаас гадна ХАСХОМ хариуцсан эрх бүхий албан тушаалтнуудад мэдүүлэг бүртгэх, гаргах, хянахтай холбоотой танхимын сургалт болон цахим сургалт зохион байгуулав.

**Зорилт 2.** Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж чанар хүртээмжийг нь сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх

4.1.2.1.1. “Nema.gov.mn” цахим хуудасны “Хууль, эрх зүйн булан”-д Онцгой байдлын байгууллагын үйл ажиллагаанд мөрдлөг болгох Монгол Улсын Засгийн газрын тогтоол, Шадар сайд, Хууль зүйн сайд, Монгол Улсын Ерөнхий прокурор болон Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаалаар батлуулсан журам-22, дүрэм-15, заавар-9, стандарт, шаардлага-6, бусад-3, нийт 55 баримт бичгийг байршуулсан.

Мөн цахим хуудасны “Холбоос” хэсэгт олон нийтээс санал, хүсэлт гаргах боломжийг нээн ажиллуулж байна.

4.1.2.1.2. Монгол Улсын Засгийн газраас иргэдэд үйлчлэх “11-11” төвөөр дамжуулж 340 санал, хүсэлт, гомдол, шүүмжлэл, талархалыг хүлээн авснаас 260 өргөдөл, гомдолд хариу өгсөн байна. Онцгой байдлын ерөнхий газарт холбогдох санал, хүсэлт, гомдол, шүүмжлэл, талархалыг хүлээн авах “11-11” төвтэй холбогдох эрхийг 2017 оны 11 дүгээр сард Засгийн газрын хэрэг эрхлэх газраас дахин олгосон бөгөөд энэ асуудлыг Захиргааны удирдлагын газрын Дотоод ажил, өргөдөл, гомдол хариуцсан мэргэжилтэн хяналт тавин ажиллаж байна.

4.1.2.4.3. Онцгой байдлын байгууллагын хэмжээнд 2017 онд 23498 аж ахуйн нэгж, байгууллага, 136945 айл өрхөд гал түймрийн хяналт шалгалт хийж, гал түймрийн хэрэг, зөрчилд хүргэж болзошгүй 114660 зөрчил, дутагдал илрүүлж, 33693

зөрчлийг үзлэг шалгалтын явцад арилгуулан, зөрчлийг арилгах заавал биелүүлэх 5820 албан шаардлага, 6466 мэдэгдэл, 401 танилцуулга 1211 дүгнэлт гаргасан байна.

Гал түймэр гарч болзошгүй 104 объектын үйл ажиллагааг хэсэгчилэн буюу түр хугацаагаар зогсоох арга хэмжээ авсан бөгөөд Галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж зөрчсөн аж ахуйн нэгж, байгууллагын холбогдох албан тушаалтан, иргэдийг 158.7 сая төгрөгөөр торгож, галын аюулаас урьдчилан сэргийлэх сургалт 2683 удаа, дадлага 1724 удаа зохион байгуулж, олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр 2017 удаа сэрэмжлүүлэг явуулсан байна.

Тайлант хугацаанд давхардсан тоогоор 16 удаа албаны шалгалт, 6 аймгийн онцгой байдлын газарт иж бүрэн шалгалт, онцгой байдлын ерөнхий газрын харъяа бүх салбар нэгжүүдэд биелэлтийн шалгалтыг зохион байгуулж, дүнг Онцгой байдлын ерөнхий газрын даргын зөвлөл, Ёс зүйн албанд танилцуулж, гарсан шийдвэрийг бие бүрэлдэхүүнд танилцуулж ажилласан.

Онцгой байдлын ерөнхий газрын Ёс зүйн алба 2017 онд дараах асуудлыг авч хэлэлцэн шийдвэрлэсэн. Үүнд:

Ёс зүйн зөрчил гаргасан 2 албан тушаалтны үндсэн цалинг 3 сар 20 хувь, 2 албан тушаалтны үндсэн цалинг 1 сар 20 хувь, 1 албан тушаалтны үндсэн цалинг 1 сар 10 хувь тус тус бууруулж,

Мөн 2 алба хаагчийг цэргийн алба хаасны тэтгэвэрт, 2 алба хаагчийн ажлын байрыг өөрчлөх, ажлын байрны шаардлага хангаагүй 1 алба хаагчийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх саналыг гаргаж шийдвэрлүүлэн, гарсан шийдвэрийг бие бүрэлдэхүүнд мэдээлж ажилласан байна.

4.1.2.7.1. Үндэсний Аудитын газраас 2017 оны 11 дүгээр сард Онцгой байдлын ерөнхий газрын 2016 оны санхүүгийн тайланд үнэлгээ хийж, дүгнэлт гаргасан бөгөөд дүгнэлтийг Онцгой байдлын ерөнхий газрын цахим хуудсанд бүрэн эхээр нь байршуулсан.

**Зорилт 3.** төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх

4.1.3.3.1. Шилэн дансны тухай хууль, тогтоомжид нийцүүлэн Онцгой байдлын ерөнхий газрын Санхүү, хангалт, хөрөнгө оруулалтын газрын мэргэжилтнүүд хариуцсан үүрэг, чиглэлийн дагуу цаг тухай бүрт нь мэдээллийг цахим хуудсанд байршуулж байна.

Онцгой байдлын албанаас 2016, 2017 онд тэтгэвэрт гарсан болон нэг удаагийн тэтгэмж авах 252 алба хаагчийн нэрсийн жагсаалтыг Онцгой байдлын ерөнхий газрын цахим хуудасны "Санхүү тэтгэвэр, тэтгэмж булан"-д тавьж нийтэд мэдээлсэн

4.1.10.1.1. Онцгой байдлын байгууллагын хэмжээнд зохион байгуулсан 23 дотоод сургалтад Авлигатай тэмцэх газар болон нийслэлийн Прокьюрорын газрын холбогдох мэргэжилтнүүдийг урьж "Авлигын эсрэг урьдчилан сэргийлэх, соён

дээшлүүлэх;

гэрээлүүлэх үйл ажиллагааг үе шатай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг

Б.Батчимэг нарыг хуулийн дагуу оролцуулав.

- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын санал болгосноор иргэд

- Оёдлын үйлдвэрлэл эрхлэгчдийн нэгдсэн холбооны ерөнхийлөгч Т.Доржготов

Я.Ишжамц

- Гал унтраах техникийн олон төрөлт спортын удирдах зөвлөлийн гишүүн

- Монголын хуульчидын холбооны гишүүн Ч.Батбаяр,

Төндөрийн үнэлгэний хороо тус бүрт мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллага, иргэдийн төлөөлөлөөс оролцуулж ажилласан. Үнд:

санаачилгыг дэмжих;

нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвх

Төвийн үрсэл зардалаар худалдан авах хувцас хэрэглэлийн жасгаалтыг Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2017 оны өдрийн А/74 тоот тушаалаар батлуулсан ба Сангийн сайдын баталсан жишиг маягтуудын дагуу төндөрийн баримт бичгийг боловсруулж, tender.gov.mn, neta.gov.mn цахим хуудас, Зүүнхүмүүн мэдээ өдөр тутмын сонинд 2 удаа нээлттэй төндөрийн зарыг байршуулсан. Төндөрт оролцогчийн шалгарсан ба шалгараагүй хуулийн үнлэснэл шалтгааны талаарх мэдээллийг дээрхи цахим хуудсаар мэдээлж, оролцогч тус бүрд мэдэгдлийг албан бичгээр хүргүүлсэн.

Төног төхөөрөмжийг бүрэн нийлүүлсэн.

4.1.4.1.1 Монгол Улсын Шадар сайдын баталсан 2017 оны Худалдан авах ерөнхий төлөвлөгөөний дагуу Шүүрхай удирдлага, зарлан мэдээлэх төвийн өргөтгөлийн төног төхөөрөмжийн жасгаалтыг Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2017 оны А/61 тушаалаар батлуулан Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлсэн ба тус газарт төндөр зарлагдан гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүд шалгарч

харилцалтыг дээшлүүлэх;

болгож, үр ашгатай, шударга, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналт,

Зорилт 4. Худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй

гэгээрүүлэх” чиглэлийн сургалтыг авахаас гадна нийслэлийн хүрээний Онцгой байдлын анги, байгууллагуудын мэдээллийн цаг арга хэмжээнд ОБЕГ-аас нийтдээ 5 удаа сургалт зохион байгуулсан.


4.1.10.1.4. Авлигатай тэмцэх газраас бэлтгэн ирүүлсэн нийт 120 ширхэг “Нийтийн албан тушаалтнуудад зориулсан гарын авлага-2015”, “ХАСХОМ-ийг бүртгэх, хянах, хадгалах ЭБАТ нарт зориулсан гарын авлага”-ийг Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын ХАСХОМ хариуцсан эрх бүхий албан тушаалтнуудад болон алба хаагчдад тус тус тараав.

Онцгой байдлын ерөнхий газрын “Nema.gov.mn” цахим хуудсыг Авлигатай тэмцэх газрын цахим хуудастай холбон “Хууль эрх зүйн”-ийн цонхонд Авлигын эсрэг үйл ажиллагааны 2017 оны төлөвлөгөөний биелэлт, Авлигын эсрэг үйл ажиллагааны 2018 оны төлөвлөгөө, ХАСХОМ гаргах албан тушаалтанд зориулсан зааврыг байршуулсан болно.

#### ***Дүгнэлт.***

Улсын Их Хурлын 2016 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 51 дүгээр тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”, Засгийн газрын 2017 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 114 дүгээр тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 2017 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, 6 зорилтын хэрэгжилтийг тооцож үзэхэд биелэлт 100 хувьтай хэрэгжиж байна.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД  
АУДИТЫН ХЭЛТСИЙН ДАРГА, ДЭД ХУРАНДАА



Г.БАТ-ЭРДЭНЭ